



ХОРИХ АНГИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ХҮЧ СУЛРАХ ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

CAUSES OF WEAKENED SECURITY FORCES IN PRISONS AND ITS PREVENTIVE MEASURES

Д.Өлзийбат*

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын докторант
Col. Ulziibat D, Ph.D Candidate in Court Decision Execution, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: buynaab140@gmail.com

Хураангуй: Хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлаж дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн ажилладаг. Нийгмийн аюулгүй байдлын хүрээнд хоригдлыг тусгаарлах, тэдэнд тогтмол хяналт тавихад хорих ангийн харуул хамгаалалтын хүч хэрэгсэл чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд удирдлага зохион байгуулалтын хувьд нарийвчлан зохион байгуулагдсан байх учиртай. Гэвч хүний нөөцийн дутмаг байдал, батлагдсан норматив хэмжээнд хүрэхгүй байх болон бусад хүчин зүйлээс хамааран хорих ангийн харуул хамгаалалтын хүч сулрах нөхцөл бий болдог байна.

Өгүүлэлд хорих ангид үйлдэгдэх гэмт хэрэг, харуул хамгаалалтын хүч сулрахад хүргэж буй хүчин зүйл, эдгээрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар судлан үзсэн.

Өгүүлэлд анализ, харьцуулан судлах, статистикийн шинжлэх ухааны түгээмэл аргуудыг ашигласан болно.

Abstract: The detention centers and prisons maintain isolation from society of the person who has committed a crime, prevention of reoffending, rehabilitation, and conduct influential work. In the context of social security, prison guards play an important role in isolating prisoners and regularly monitoring them, and said management should be organized in detail. However, depending on the lack of human resources, non-compliance with approved standards, and other factors, the security forces of prisons are weakened.

The article examines crimes committed in prisons, the factors that lead to the weakening of security forces and the experience of foreign countries in preventing them.

The article uses common methods of analysis, comparative research, and statistical science.

Түлхүүр үгс: Хоригдол, хорих байгууллага, аюулгүй байдал, урьдчилсан сэргийлэх

Keywords: Prisoners, prisons, security and preventive measures

Үндсэн хэсэг

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийтгэх тогтоолд заасан хугацаа, байгууллагын төрөл, ял эдлүүлэх зэрэглэл, нөхцөл журмын хүрээнд хорих ялыг эдлүүлж буй төрийн албадлагын арга хэмжээ бөгөөд хорих ял шийтгүүлсэн хүнд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх үр дүнтэй арга бол хорих байгууллагын харуул хамгаалалтын хүчийг зөв зохион байгуулах, хяналтын болон харуул

хамгаалалтын дэвшилтэт техник хэрэгслийг ашиглах юм.

Судалгаагаар 2023 оны жилийн эцсийн байдлаар хорих ангиудад 228, цагдан хорих байруудад 56, нийт 284 зөрчил гарсныг судлан авч үзвэл хорих ангийн дотоод журам зөрчсөн 25, хоорондоо маргалдаж бусдыг доромжилсон 151, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага биелүүлээгүй, эсэргүүцсэн 64, хөдөлгөөнт утас ашигласан 20, зөрчил гарчээ. Эдгээр зөрчлүүдийг харуул хамгаалалтын хүчээр, хяналтын

техник хэрэгсэл, үзлэг нэгжлэгийн явцад илрүүлсэн, болзошгүй томоохон сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлсэн гэдгийг онцлох нь зүйтэй.

Хорих ял эдлүүлэх байгууллагын найдвартай харуул хамгаалалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэн чухал зорилтуудын нэг бөгөөд харуул хамгаалалтын хүч хэрэгслийг зөв зохион байгуулах, хяналт сулрахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Үүнтэй холбогдуулан *хорих ангийн харуул хамгаалалтын хүч сулрах шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх зарим асуудал...*” ерөнхий сэдвийг дараах 3 асуудлын хүрээнд тоймлон авч үзсэн. Үүнд:

1. Хорих ангийн харуул хамгаалалтын хүчийг сулруулж буй шалтгаан нөхцөл, хүндрэл бэрхшээл;
2. Төрийн тусгай алба хаагчид болон гадаадын зарим улс орны ижил чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагууд цалин хангамжид хийсэн харьцуулалт,
3. Хорих ангийн биечилсэн хяналтаар илрүүлэх шинж тэмдэг, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
4. Дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Хорих ангийн харуул хамгаалалтын хүчийг сулруулж буй шалтгаан нөхцөл, хүндрэл бэрхшээл.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилладаг” төрийн тусгай алба бөгөөд шүүхээс төр, нийгэмд аюултайд тооцогдсон гэмт хэрэг үйлдэж, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн хорих ялыг албадан эдлүүлэх байгууллага нь хорих анги байдаг ().

1.Хорих ангийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байж сая хорих ялын зорилго биелдэг билээ. Гэтэл сүүлийн үед “хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, төрийн тусгай байгууллагын

хүчийг сулруулах, оролдлого” удаа дараа гарч байгааг цахим орчин дахь мэдээ, мэдээлэл, уран сайхны кино, бусад баримтууд харуулж байна. Жишээ нь сүүлийн жилүүдэд бүтээгдэж байгаа уран сайхны кинонуудад хорих ангид дарамт шахалт байдаг, оргон зайлахад амар мэт байдлыг харуулсан байна.

Кейс 1. ... уран сайхны кинонд хорих ангиас оргосон хоригдол цасан дор нуугддаг хэсэг нь ... дугаар хорих ангиас оргосон хоригдолд дуурайх сэдлийг өгснийг үгүйсгэж болохгүй юм.

Иймд нийгэмд хамгийн ойр хүрэх уран сайхны бүтээлүүдэд байгууллагын үйл ажиллагааг бодитоор харуулах шаардлага бий болоод байна.

2. Хорих байгууллагын алба хаагчид тэр дундаа харуул хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчид хамгийн өндөр эрсдэл бүхий нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цагдан хоригдсон этгээд нийгмээс тусгаарлагдсан үедээ хамгийн их сэтгэл зүйн тогтворгүй байдалд орж үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарт бухимдлаа гаргаж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гаргадаг нь 24 цагийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж ажлаас халшрах үр дагаврыг бий болгодог. Энэ нь харуул хамгаалалтын алба хаагч нарын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлийг алдагдуулж бие эрхтэндээ гэмтэл учруулах, амиа хорлох, бусад хоригдогч, хоригдлуудтай маргаан үүсгэх, эд зүйл эвдэх, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, хэл амаар доромжлох, занал хийлэх, дотоод журам зөрчих, өлсгөлөн зарлах, суурь өвчин сэдрэх, сэтгэл гутралд орох, хахуул өгөх, авлига авахыг санал болгох, танил тал, найз нөхөд, албан тушаал, улс төр, бизнесийн нөлөөлөл үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх зэрэг гаднын олон сөрөг нөлөөлөл ихээр үзүүлдэг байна.

3.Харуул хамгаалалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж буй “удирдлагын зохион байгуулалт” нь харуул хамгаалалтын хүчийг хууль, журамд заасны дагуу зөв зохион байгуулах үүрэг хүлээдэг хэдий ч зарим тохиолдолд харуул





хамгаалалтын “*мэргэшсэн бус нэгжийн алба хаагчдыг дайчлан хоногийн жижүүрийн үүргийг гүйцэтгүүлдэг*” нь хууль, журам зөрчигдөх, цаашлаад гэмт хэрэг, зөрчил гарах, харуул хамгаалалтыг хүчийг сулруулах хүчин зүйл болж байна.

4.Түүнчлэн хорих ангиудын алба үүргээ гүйцэтгэх орчин нөхцөл харилцан адилгүй, хөдөө орон нутаг, алслагдсан байршил нь “*...нийгмийн үйлчилгээ хол, төвийн инженерийн байгууламжид холбогдоогүй, албан контор, хоригдлын байрууд бага оврын нам даралтын зуухтай, өвлийн улиралд нүүрс татан авах, галлагааны горим алдагдах эрсдэл өндөртэй, гүний худгаас цэвэр усаа зөөж тээвэрлэн хэрэглэдэг, бохирын иж бүрэн системгүй, модон жорлонтой...*” гэх зэрэг нөхцөл байдлууд нь алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллахад сөргөөр нөлөөлж байна.

Хорих ангиуд нь өөрийн онцлогоос хамаарч аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж төсөвт болон байгууллагын хэвийн ажиллагааг хангахад дотоод орлого төвлөрүүлэн ажиллаж, төсвийн ачааллыг багасган өөрийн үйл ажиллагаа дахь хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх гарц нь хорих байгууллагын дотоод үйлдвэрлэл байдаг бөгөөд “*...хоригдлыг нийгэмшүүлэх, хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох, сургалт зохион байгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх...*”-д туслах аж ахуй гол үүрэг гүйцэтгэдэг билээ.

Олон нийтээс тусгаарлагдсан тодорхой тооны хүмүүсийг хорих ангийн байрлалд төвлөрүүлэн харж хамгаалахад хүний наад захын эрхийг хангахаас эхлээд суллагдах хүртэл тасралтгүй үргэлжлэх хэрэгцээг хуульд заасны дагуу зохион байгуулах үүрэг хүлээдэг онцлогтой (Энхбаяр, 2007).

Дээрх ажлыг зохион байгуулах, хоригдлыг хөдөлмөрлүүлэх явцад харуул хамгаалалт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтыг хийж, биечилсэн хяналт тавих ажиллагаанд харуул хамгаалалтын хүч туйлын дутагдалтай байдаг.

5.Хорих ангийн харуул хамгаалалтын хүч сулрах шалтгаан, нөхцөлд тухайн анги, нэгж дээр гарсан гэмт хэрэг, ноцтой зөрчил, учралын үед хүч сулардаг. Тухайлбал хорих ангиас хоригдол оргох тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагаанд хорих ангийн харуул хамгаалалт, гүйцэтгэх албаны удирдлагад харуул хамгаалалтын алба хаагч нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж эрэн сурвалжлах ажиллагаанд оролцуулдаг.

Энэ нь тухай хорих ангийн харуул хамгаалалтын хоногийн жижүүрийн бүрэлдэхүүний хүчийг дайчлан ажиллуулж, харуул хамгаалалтын үндсэн хүчнээс “*...шуурхай бүлгийн орон тооны бус бүлгийн хүч, хэрэгслээр зохион байгуулж ирсэн нь...*” хорих ангийн өдөр тутам үүрэг гүйцэтгэх хоногийн жижүүрийн бүрэлдэхүүний хүч дутагдаж тодорхой хугацаанд 24/24 цагаар ажиллуулж ирсэн нь дотоод нөхцөл байдалд эрсдэл үүсэх шалтгаан нөхцөл болдог.

Хоногийн жижүүрийн бүрэлдэхүүн 24 цагаар тасралтгүй биечлэн хяналт тавьж ажиллаад дахин 24 цагийн дараа нойргүй үүрэг гүйцэтгэхэд хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчихөөс гадна, хувь хүний хувийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

6.Ажлын ачааллын жишиг нормативыг бүрэн хангаагүй нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”(Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, 2017) -аар хаалттай хорих ангиуд 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” гэж заасан мөн жишиг

нормативд 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалттай боловч одоогоор алба хаагчдын орон тоог жишиг нормативд зааснаар нэмэгдүүлээгүй зарим хорих анги байгууллагууд харуул хамгаалалтыг гурван ээлжээр зохион байгуулан ажиллаж байна.

Хоригдлын тоо 5500 орчим байх хугацаанд 1 харуул хамгаалалтын ажилтны биечлэн хяналт тавих хоригдлын тоо дунджаар 70-80 байсан бөгөөд 2015, 2016

онуудад “Өршөөл үзүүлэх тухай хууль”, “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль” хэрэгжсэнээр өршөөл, хуулийн тэгшитгэлд хамрагдан нийт 3495 хоригдол шууд суллагдаж, 2746 хоригдлын эдлэх ялаас дүйцүүлэн хассан тул нийт хоригдлын тоо буурч, ажлын ачаалал жишиг нормативд ойртож байсан боловч хоригдлын тоо жилд дунджаар 400 хоригдлоор нэмэгдэж. Ажлын ачаалал буцаад нэмэгдэх хандлагатай байна.




График-1. Хоригдол, хоригдогчийн тоо

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2018-2022 оны хугацаанд нийт 16 гэмт хэрэг гарсан ба үүнийг өнгөөр нь авч үзвэл оргох 12 буюу

75 хувь, хүний биед гэмтэл учруулсан 3 буюу 18.75 хувь, хууль сахиулагчийг эсэргүүцэх 1 буюу 6.25 хувийг тус тус эзэлж байна.

№	Гэмт хэрэг	2018	2019	2020	2021	2022	Нийт
1	Оргох	3	1	4	-	4	12
2	Хүний биед гэмтэл учруулах	1	1	-	1	-	3
3	Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	1	-	-	-	1
Нийт		4	3	4	1	4	16

Хүснэгт-1. 2018-2022 онд ШШГБ-ын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт

2018-2022 оны хугацаанд нийт 1397 зөрчил гарсныг өнгөөр нь авч үзвэл гар утас ашигласан 115 буюу 8.2 хувь, архи уусан 14 буюу 1 хувь, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн 362 буюу 25.9 хувь,

бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон 763 буюу 54.6 хувь, хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн, хадгалсан 143 буюу 10.2 хувийг тус тус эзэлж байна.

№	Зөрчил	2018	2019	2020	2021	2022	Нийт
1	Гар утас ашигласан	56	18	20	11	10	115
2	Архи уусан	9	2	-	2	1	14





ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

3	Албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн	86	80	89	56	51	362
4	Бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон	180	145	151	125	162	763
5	Хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн хадгалсан	30	24	24	23	42	143
Нийт		361	269	284	217	266	1397

Хүснэгт-2. Хоригдлын зүгээс үйлдсэн зөрчлийн судалгаа

Нээлттэй хорих ангийн хувьд хорих ангийн амьдралын бүсээс гадна хууль, журамд заасны дагуу хоригдлыг гэрээгээр ажиллуулах үед харуул хамгаалалтыг ээлжийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэдэг хамгаалалтын ажилтнаас томилон үүрэг гүйцэтгүүлж байгаа нь хамгаалалтын хүч сулрах шалтгаан болж байна.

Хорих байгууллага нь хоригдлыг цалинтай ажлын байраар хангаж гэм хорын хохирол төлбөрийг барагдуулах чиг үүрэгтэй ч нөгөө талаар хорих ангийн харуул хамгаалалтын хүч дутагдаж эрсдэлийн төвшнийг өндөр болгодог. Хорих ангийн хориотой бүсээс гадна гэрээгээр ажиллуулах хоригдлыг Хорих ял эдлүүлэх албанд танилцуулж, прокурорын зөвшөөрлөөр гарган ажиллуулах тохиолдолд хүчний харьцааг 5-6 хоригдолд 1 алба хаагч, 10-15 хоригдолд 2 алба хаагч, 16-20 хоригдолд 1 офицер, 2 ахлагч гэх

зэргээр тооны харьцаанаас хамаарч хамгаалалтын хүчийг нэмэгдүүлдэг. Тэр хэмжээгээр хоногийн жижүүрийн бүрэлдэхүүний хүч дутагдаж бүрэн амарч чадаагүй алба хаагчийн нөхөн гаргаж түр ажиллуулж байгаа өнөөгийн практик учир дутагдалтайг харуулж байгаа юм. Цаашид хэсэг, салбарт гэрээгээр ажиллуулах хоригдлыг хоногийн жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг үндсэн хүчнээс гадна орон тоог шийдвэрлэн ажиллуулах нь эрсдэлийг багасгаж харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаа хангагдана.

Хаалттай хорих ангид 1 харуул хамгаалалтын ажилтан 20-оос дээш хоригдолд биечилсэн хяналт тавих тохиолдолд тогтмол бүрэн хяналт тавих боломжгүй болж, хоригдлууд урьдчилан төлөвлөсөн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж үүсдэг тул хоригдлын зүгээс үйлдэх гэмт хэрэг, зөрчил буурахгүй байх хандлагатай байна.

Эрсдэлийн төрөл	Ач холбогдлын зэрэг	Тохиолдох магадлал	Үзүүлэх нөлөөлөл	Эрсдэлийн нийт тоон түвшин	Тайлбар	Дагалдан гарах үр дагавар
Батлагдсан жишиг нормативд хүрэлцэхүйц	Дунд	4	2	8	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын жишиг норматив”-аар	-Ажлын ачаалал ихтэй байдгаас алба

орон тоо хангалтгүй.					-Нээлттэй, хаалттай хорих ангид 20 хоригдол тутамд 1 хамгаалалтын ажилтын хяналт тавихаар тогтоосон боловч практикт 80-100 хоригдолд 1 хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллаж байна. -Нээлттэй хорих ангид 60-70 хоригдолд 1 нийгмийн ажилтан, хаалттай хорих ангид 50-60 хоригдол тутамд 1 нийгмийн ажилтан нээлттэй, хаалттай хорих ангид 50-60 хоригдолд 1 сэтгэл зүйч мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ гэж тогтоосон боловч өнөөдрийн байдлаар хорих анги байгууллагад 1 нийгмийн ажилтан 100-120 хоригдолд, 100-150 хоригдолд 1 сэтгэл зүйч мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа нь, ажлын ачааллыг 2-3 дахин ихэсгэж байна. 24/72 цагийн хуваариар ээлж бүрд 1 дүрс бичлэгийн ажилтан гэж заасан боловч энэ орон тоо батлагдаагүй, хяналтын гэж заасан боловч энэ орон тоо батлагдаагүй	хаагчид шантрах, улмаар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх -Харуул хамгаалалтын хяналтын хүч сулрах, байгууллагын үйл ажиллагаа доголдох -Харуул хамгаалалтын хүч суларснаар оргох болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх
-------------------------	--	--	--	--	---	--

Хүснэгт-3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эрсдэлийн үнэлгээний тайлангаас

Хорих анги, байгууллагын биечилсэн харуул хамгаалалт сул, хүн хүчний хүрэлцээ муугаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2018-2022 оны хугацаанд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнээс оргох гэмт хэрэг 12 буюу 63.2 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2019 онд Прокурорын байгууллагаас “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-т заасны дагуу хорих анги, байгууллагын бүтэц орон тоог зохион байгуулаагүй” гэх үндэслэлээр Булган аймгийн ерөнхий прокурорын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 07/262 дугаар, Улсын ерөнхий прокурорын туслах прокурорын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 6/06 дугаар, Орхон аймгийн ерөнхий прокурорын 2019 оны 06 дугаар 17-ны өдрийн 6/06 дугаар шаардлагыг тус тус ирүүлж байжээ.

Хорих байгууллага нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж хорих ялаар

шийтгэгдсэн хүмүүсийн бөөгнөрөл тул тэдний зүгээс гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг. Иймээс нэн тэргүүнд дараах 3 орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Дүрс, бичлэгийн хяналтын ажилтны орон тоо батлагдаагүй хорих анги, байгууллагуудад хамгаалалтын ажилтан, холбоочин зарим тохиолдолд ерөнхий жижүүрүүд уг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа нь хоригдол, хоригдогчид тавих хяналт суларч гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй байх тул дүрс бичлэгийн хяналтын ажилтныг томилуулах;

Батлагдсан орон тоогоор хамгаалалтын ажилтны тоо их харагдаж байгаа боловч ШШГБ-ын хэмжээнд 24 цагийн жижүүрийн үүргийг гүйцэтгэн 139 харуул хамгаалалтын ажилтан ажиллаж байна. Бусад хамгаалалтын ажилтан нь хорих ангийн гадна хамгаалалт, нэвтрэх хэсэг, хуяглан хүргэх ажиллагаа, үйлдвэрлэлд үүрэг гүйцэтгэдэг тул хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх зэрэг болно.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн шаардлага гэдэг ойлголтод юуг



МОНГОЛЫН ХУУЛЬ
ХАМГААЛАХ
ХААГЧИД



ᠬᠤᠭᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠤᠯᠠᠬᠤᠢ

хамааруулан авч үзвэл зохих тухай авч үзвэл:

А. Хоригдлын шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох зорилгоор түүнийг олон нийтээс тусгаарлан байнгын харуул хамгаалалттай нөхцөлд байлгах

В. Үүргээ ухамсарлан түүнийгээ алхам тутамдаа хэрэгжүүлдэг дадал заншилд хэвшүүлж сургах

С. Хоригдлын үйлдсэн гэмт хэргийн хор, аюул хувийн байдал, хүмүүжлийн төвшнийг харгалзан тэднийг өөр өөр нөхцөлд хорьж ялыг нь эдлүүлэх асуудлыг хамааруулан ойлгож болох юм. Дээрх шаардлагуудын нийлбэр нь дэглэм, журмын асуудлыг тодорхойлж өгдөг. Хоригдлыг олон нийтээс тусгаарлан хорих гэдэг нь түүнийг эрүүгийн хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлан зохих шүүхийн шийтгэх тогтоолд заасан дэглэмийн хорих анги, гянданд албадан байлгаж ялыг нь эдлүүлэх үйл ажиллагаа юм. Дэглэмийн энэ шаардлага нь хоригдлыг хорих ял эдлэх хугацаанд байнгын хатуу харуул хамгаалалтад байлгаж улмаар түүний зан байдал, үйл хөдөлгөөнд нь хууль дүрмийн дагуу хатуу хяналт тавих замаар хэрэгжинэ. Хоригдлыг олон нийтээс тусгаарлан байнгын харуул хамгаалалтад байлгах шаардлага нь нэг талаар шүүхийн тогтоолд заасан ялын зорилгыг хангах, нөгөө талаар зөвхөн хоригдлын төдийгүй бусад иргэдийг аливаа гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

Дүгнэлт

Сүүлийн үед хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч буй “...уран сайхны кино, баримт нотолгоогүй мэдээ, нийтлэл, хилс хэрэгт гүтгэгдсэн гэх хорих ялаар шийтгэгдсэн этгээд, тэдгээрийн ар, гэр, өмгөөлөгч, ах дүү нар, найз нөхөд хамаарал бүхий этгээдээс харуул хамгаалалтын хүчийг сулруулах оролдлогуудыг байнга гаргаж байгаа...” харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын “...албандаа итгэх итгэл үнэмшил, сэтгэл зүй, тогтвортой ажиллах нөхцөлийг алдагдуулж байгаа...” асуудлыг онцгойлон анхаарч хууль, эрх зүйн хүрээнд

шийдвэртэй арга хэмжээ авах шаардлага байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудын “...хэвийн үйл ажиллагааг хангах, хүний нөөцийн дутагдал, тэдний нийгмийн баталгааг хангах арга хэмжээ...” нь одоогийн үйлчилж буй хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага тавигдаж байна.

Судлаачийн зүгээс өмнө бүлэгт дурдсан биечилсэн хамгаалалтын арга барилд шинж тэмдгийг илрүүлэх явц нь “...хувь хүний гадаад дотоод үйл хөдлөл, харилцаанаас илрэх сөрөг үйлдэл, эс үйлдэхүйг мэдэрч үүрэг гүйцэтгэх нь ажлын арга барил, хүнтэй харилцах туршилага, гярхай байдал, тасралтгүй ажиглалтаас шалтгаалж илрүүлэлт харилцан адилгүй...” байгаад анхаарч харуул хамгаалалтын залуу боловсон хүчин, шинээр томилогдсон алба хаагч нарт энэ чиглэлийг мэдлэг, мэдээллийг олгох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Түүнчлэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д заасанчлан “...хорих ангид үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг үйлдэгч нь хорих ялаар шийтгэгдсэн этгээд буюу хоригдол хүний криминологи шинжийг нарийвчлан судлах...” явдал нь туйлын ач холбогдолтой байна.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдэж хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудын хэрэг үйлдсэн үйлдлийн арга, хэлбэр харилцан адилгүй байдаг ч төсөөтэй шинж тэмдэг олон байдаг гэдгийг судлаачид тайлбарласан. Тухайлбал, орон байрны хулгай хийдэг этгээдүүдэд илрэх шинж тэмдгүүд адил байх тохиолдлуудыг дурдвал: - айлын гэрийн хаалга, цонхыг онгойлгоход гаршсан, түлхүүр тааруулахад мэргэшсэн байдаг, - шунахай сэдэлтэй гэх мэт. Хорих ангиас хоригдлыг ажил, үйлчилгээнд гаргахдаа гэмт хэргийн зүйл анги, үйлдлийн арга, хэлбэрийг судалж, засрал хүмүүжилд голлон анхаарч гаргадаг ч уг хоригдлын суурь хүмүүжил, тогтсон дадал зуршилд байнга анхаарч байх шаардлагатай юм.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүнд орж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэх болсон нь алба хаагчдын нийгмийн баталгаа бусад байгууллагуудын адил төвшинд хүрэх эрх зүйн үндэс тавигдсан нь дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

1.Нэршлийн хувьд цэргийн алба хаагч гэдгээр нийгмийн сэтгэл зүй, хүлээн авч буй хандлага эерэг болсон;

2.Алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, албаны бэлэн байдал нь цэргийн алба хаагчийн нийтлэг шаардлагыг төвшинд хүрэх нөхцөл бүрдсэн.

3.Нийгмийн баталгаа бусад тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудын адил хэмжээнд хүрсэн.

4.Эрүү, иргэн, захиргаа, зөрчил зэрэг бүх төрлийн шүүхийн шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагын хувьд нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, удирдлага зохион байгуулалтын хувьд нэгдмэл байдлыг бий болгох ач холбогдолтой болсон.

5.Хорих ангийн харуул хамгаалалтыг цэргийн зохион байгуулалттай хослуулан хэрэгжүүлэх нь аюулгүй байдлыг хангах ач холбогдол өндөрсөн, үүрэг хариуцлага сайжирсан гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Төрөөс хүний эрхийн хангах чиглэлд анхаарал хандуулж хорих анги, цагдан хорих байрны орчин нөхцөлийг сайжруулах шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг ч тэдгээр үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулан ажилладаг хүний нөөц, тэр дундаа нийгмийн аюулгүй байдлын манаанд нүд цавчих эрхгүй ажилладаг харуул хамгаалалтын алба хаагч нарын эрх, аюулгүй байдлын баталгааг боловсронгуй болгох нь хүний эрхийг хангах хамгийн үр дүнтэй шийдэл юм.

Хорих ял эдлэгсэд нь хэрэг шалгагдахаас эхлээд ял шийтгэл хүлээх хүртэл маш олон үе шатыг дамжин хорих ангиудад хуваарилагддаг. Дээрх цаг

хугацаанд хууль, эрх зүйн мэдлэг сайжирч хуулиас гадуурх гарц боломжийг эрэлхийлэх туршлага хуримтлуулан, хорих байгууллагын алба хаагч нартай харилцахад хүндрэл үүсгэдэг. Ихэнхдээ харуул хамгаалалтын алба хаагч нарын сул талыг ашиглах, өөрт ашигтай байдал бий болгох санаа зорилгоо хэрэгжүүлдэг. Энэ тохиолдолд хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ур чадвар, ажлын туршлага, хүнтэй харилцах харилцааны соёл, хууль, эрх зүйн мэдлэг сул байх тохиолдолд эрсдэл гардаг.

Иймд хорих ангийн харуул хамгаалалтын хүч сулрахаас урьдчилан сэргийлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээнд нэн тэргүүнд анхааран авч үзэх шаардлагатай байна. Үүнд:

1.Нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж буй сөрөг мэдээллийг багасгах, үнэн зөв, бодит байдлыг албаны эх сурвалжаас авч байх,

2.Хорих байгууллагын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах,

3.Хүний нөөцийн хангалт, сургалт, нийгмийн баталгааг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

4.Хорих ангийн аюулгүй байдлыг хангах техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх,

5.Хорих ангийн биечилсэн хяналт, хамгаалалтын тооны харьцааг нэмэгдүүлэх,

6.Хорих ангийн харуул хамгаалалтын хүч сулрах бодит шалтгаан нөхцөл үүссэн үед авч хэрэгжүүлэх төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын Их Хурал. (2010 оны 7 дугаар сарын 15). *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*. (48 дугаар тогтоол).

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд. (2017). *А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал*.

Сүхбаатар, А. (2004). *Аюулгүй байдал, батлан хамгаалах, цэргийн стратеги*,





ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ ᠰᠠᠬᠢᠭᠤᠯᠠᠬᠤ

гадаад, дотоод бодлогын үндсэн асуудал. Улаанбаатар.

Бор, Ж. (2010). Жижиг улс ба Үндэсний аюулгүй байдал. *Жижиг улсын аюулгүй байдал. Өнөө ирээдүй эмхэтгэл.* Улаанбаатар.

Очгэрэл, Ц. (2017). *Хорих байгууллагын аюулгүй байдал.* Улаанбаатар.

Энхбаяр, Ж. (2007). *Аюулгүй байдлын олон талт асуудал.* Улаанбаатар.